



“Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн хүрээнд хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн туршлага

БГД – ийн “Сэтгэмж” цогцолбор сургууль



Агуулга

- Төслийн зорилго
- Туршилт хичээлийн өмнөх бэлтгэл ажил
- Туршилт хичээлд оролцогчдын үүрэг, оролцоо
- Үр дүн
- Цаашид анхаарах зүйл



Математик (Дунд)

Математик (Бага)

Мэдээлэл зүй

Хими


Туршилт хичээл

Төсөлт ажил




Хүн-орчин

Хүн-байгаль

Физик




Загвар сургуулиуд




Төсөл эхлэх үеийн ойлголт

- ▶ Японы болон өөрийн орны их, дээд сургуулийн багш нартай хамтран ажиллах
- ▶ Хүүхдийн хөгжил, сурах арга барилыг хөгжүүлэх
- ▶ Багшийн арга зүйд шинэчлэл хийх
- ▶ Хичээлийг хамтран бэлтгэх



Төсөөлөл, эргэлзээ


- ▶ Нэг талаас харахад бидний хийдэг л зүйл мэт...
- ▶ Японы сургууль багш нарын туршлага, арга зүйг өөрийн орны нөхцөлд хэрхэн буулгах боломжтой вэ?
- ▶ Төслийн үзэл санааг багш нарт хэрхэн ойлгуулах, бэлтгэх
- ▶ Ажлын ачаалал хэр нэмэгдэх, түүнийг яаж зохицуулах вэ?



Зорилго


Туршилт хичээлийг зохион байгуулж, хичээлд ажиглалт, шинжилгээ хийх, “хүүхэд төвтэй” арга зүйд суралцах

- ▶ Төслийн эхний жилд багш нар арга зүйгээ сайжруулах, шинэчлэх, ур чадвар, хөгжүүлэхэд чиглэсэн хичээлийн судалгаа хийх арга зүйд суралцах, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх
- ▶ 2 дахь жилд хичээлд бэлтгэх төлөвлөлтийн хүрээнд тасралтгүй хийгдэх тодорхой үе шат бүхий хичээлийн бэлтгэл киррикюлим судалгааны арга зүйн талаар тодорхой ойлголттой болж, төслийн үйл ажиллагааг сурталчлах, багш, суралцагчдын үйл ажиллагаанд гарсан ахиц дэвшлийг дэмжин ажиллах.
- ▶ 3 дахь жилд туршигч багш нар алдааны шинжилгээ хийх аргазүйд суралцах, төслийн үр дүн, арга зүйг түгээх ажлуудыг зохион байгуулах




Бэлтгэл, зохион байгуулалт


- ▶ Сургуулийн нийт багш нарт төслийн зорилгыг танилцуулах
- ▶ Туршилтын өмнөх үзүүлэх хичээлүүд зохион байгуулах
- ▶ Тухайн жилийн туршилт хичээл болон мониторингийн зорилго, зорилтыг сургуулийн түвшинд тодорхойлон төлөвлөх
- ▶ Тухайн жилийн туршилт хичээлийг удирдах багш нарын баг байгуулах
- ▶ Төслийн багийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг гаргах, түүний дагуу ажиллах
- ▶ Мониторингийн багийг байгуулах
- ▶ Арга зүйн төвөөс гаргасан зөвлөмжийг багш нараар судлуулах
- ▶ Мониторингийн багийг мониторингийн зааварчилгаатай танилцуулах
- ▶ Туршилт хичээлийн хуваарийг сургуулийн нэгдсэн хуваарьт тусгаж, багш нарын хичээлд зохицуулалт хийх, өрөө танхимыг танхимыг бэлдэх
- ▶ Туршилт хичээлийн үед шаардагдах сургалтын багаж төхөөрөмж, бусад хэрэглэгдэхүүнийг бэлтгэх
- ▶ Хичээлийн үеэр видео бичлэг хийх багшийг сургах
- ▶ Туршигч болон ажиглагч багш нарыг сургалтанд хамруулах



Оролцогчдын үүрэг



Сургуулийн захирал


- Төслийн багийн ахлагчаар ажиллаж, ерөнхий зохион байгуулалт хийх
 - Туршигч багш нарын хичээлд сууж мониторинг хийх
 - Сургалтын таатай орчин бүрдүүлж, хэрэглэгдэхүүнээр хангах
 - Өдөр тутмын үйл ажиллагааны талаар мэдээлэл авч, хэвийн явуулах
 - Багш нарыг урамшуулж дэмжих
 - Сургуулийн багш, эцэг эх, иргэдэд төслийг сурталчлах
 - Туршигч, ажиглагч багш нарт зөвлөж намтран ажилласан
 - Ажлын хэсгийн ажил үүргийг баталгаажуулж ажилласан
 - Туршилгаа түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцсон
- 

Сургалтын менежер

- Хичээлийн хуваарийг шинэчлэн боловсруулах
- Багш нарыг туршилт хичээлд суулгаж ажиглалт хийхэд суралцуулах
- Хичээлийн хэлэлцүүлгийг удирдан явуулах
- Үнэлгээний хуудсуудыг нэгтгэж боловсруулан, дүн шинжилгээ хийх
- Туршигч, ажиглагч багш нарт зөвлөн хамтарч ажиллах
- Ажлын хэсэг, туршигч багш нарыг холбож ажилласан
- Бүтээлийн үзэсгэлэн гаргасан
- Туршилт хичээлийг баримтжуулах
- Анги танхимийн зохицуулалт хийх

Ажиглагч багш нар

- ▶ Арга зүйн зөвлөмж, ээлжит хичээлийн хөтөлбөртэй танилцах
- ▶ Хичээлд ажиглалт хийх, мониторингийн зааварчилгаатай танилцаж хэрэглэх
- ▶ Туршилт хичээлийн бэлтгэл хангахад туршигч багшид тусалж хамтран ажиллах
- ▶ Хичээлийн явцын тэмдэглэл хөтлөх
- ▶ Хичээлд тодорхой үүрэгтэйгээр ажиглалт хийх
- ▶ Хичээлд үнэлгээ өгөх хуудсыг хөтлөх
- ▶ Хичээлийн хэлэлцүүлэгт оролцож санал бодлоо солилцож, харилцан суралцах
- ▶ Өөрийн сургалтын үйл ажиллагаанд тусгаж ажиллах
- ▶ Бусад багш нарт төслийн үйл ажиллагааг сурталчлах




Туршигч багш нар

- Арга зүйн зөвлөмжтэй танилцах
- Ажлын хэсгийн багш нартай хамтарч ажиллах
- Ээлжит хичээлийн бэлтгэлийг хангах
- Туршилт хичээлийг удирдан зохион байгуулах
- Нэгж хичээлийн дараа хичээлд үнэлгээ өгөх
- Зөвлөмжид өөрийн санал бодлыг тусгах
- Эцэг эх, багштай хамтран ажиллах
- Багш сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргах


Тулгарсан бэрхшээл

- ▶ Анги танхимын хүрэлцээ бага
- ▶ Ажлын хэсэг болон, загвар 2 сургуультай зохицуулж хичээлийн хуваариа гаргах
- ▶ Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлтөнд урьдчилан тусаагүйгээс зарим ажил давхардсан
- ▶ Анхны жил мониторинг хийхэд хамгийн хэцүү байсан
- ▶ Зайлшгүй шаардлагатай хэрэглэгдэхүүн сургуульд байхгүй
- ▶ Эхний үед нэмэлт ачаалал ихтэй мэт санагдаж байсан



Арга зам

- ▶ Хаашаа ч гарахгүй хийх л ёстой зүйл байсан тул бэрхшээлээс гарах арга зам хайж, өөр, өөрийн нөөц бололцоог ашиглан бүгдийг зохицуулж чадсан.
- ▶ Хичээлийн хуваариа загвар сургуулийн менежерүүд хамтран боловсруулсан
- ▶ Өөрийн сургуулийн хичээлийн хуваарийг үүндээ зохицуулан өөрчилсөн.
- ▶ Хэрэглэгдэхүүний тухай асуудлыг эцэг, эх, ажлын хэсгийнхэнтэй хамтран шийдсэн
- ▶ 2 дахь жилээс мониторингийг цахим хэлбэрээр хийх нэгдсэн аргачлалтай болсон
- ▶ Бидний өмнө нь хийж л байсан, цаашид хийх л ёстой ажил гэдэг нь мэдрэгдэж эхэлсэн




Багшид гарсан өөрчлөлтүүд

- ▶ Багшийн яриа багасан, суралцагчдаа хүлээцтэй сонсох
- ▶ Суралцагчдад өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох болсон
- ▶ Багшийн суралцагчидтайгаа харилцах харилцаа дотно, нөхөрсөг болсон
- ▶ Хичээлийн дараах хэлэлцүүлгээс бие биеэсээ суралцах хандлага нэмэгдэн, багшийн сэтгэлгээнд өөрчлөлт гарсан
- ▶ Тухайн сэдэвтэй холбоотой онолын мэдлэг дээшилж, хичээлийн дидактик алхмуудыг бодитойгоор мэдрэх болсон
- ▶ Сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хэрэглэх чадвар нэмэгдсэн.




Суралцагчдад гарсан өөрчлөлтүүд

- ▶ Суралцагчид өөртөө итгэлтэй болж, бие даан асуудлыг шийдвэрлэх хандлагатай болсон
- ▶ Хичээлдээ сонирхолтой болж хамтран ажиллаж бусдыгаа сонсож, бусдын хийсэн үйлд дүгнэлт өгч, бусдад ярьж сурсан
- ▶ Ажиглалт хийн, таамаглал дэвшүүлж, туршилт хийж, дүгнэлт гаргах, харьцуулан жиших чадвар дээшилсэн
- ▶ Ойлгосон зүйлээ зургаар, бичгээр, үгээр илэрхийлэх чадвар сайжирсан




Сургамж, анхаарах зүйл

- ▶ Төслийг бодитой хэрэгжүүлэхэд оролцогч бүрийн үүрэг тодорхой байх нь чухал
- ▶ Төсөл эхлэх үед өөрийн болон хамтрагчдынхаа сэтгэл зүйг сайн бэлтгэх
- ▶ Төслийн үйл ажиллагааг сургуулийн ерөнхий төлөвлөлт, үйл ажиллагаанаас тусад нь авч үзэхгүй байх
- ▶ Бага боловч ахиц, өөрчлөлтийг олж харан өөртөө болон хамтрагчиддаа урам өгч байх
- ▶ Чин сэтгэлээсээ хамтран ажиллах, бие биенээ дэмжих





Анхаарал тавьсанд баярлалаа.




Цаашид анхаарах зүйл

- Сургуулийн ажлын төлөвлөгөөнд төслийн үзэл санааг тусгах
- Багш нарыг дэмжих урамшуулах
- Төсөлд хамрагдсан сургуулиудын үйл ажиллагааг ойлгож дэмжих
- Эцэг эхчүүдийг татан оролцуулах





Буцах



Буцах